



НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРОО, ЗАЛГАМЖ ХАЛААНЫ БОДЛОГО

НЭГ. ЗОРИЛГО

- 1.1. Энэхүү баримт бичгээр "Нэткапитал финанс корпораци ББСБ" ХХК /цаашид "Групп" гэх/-ийн эрх бүхий албан тушаалтны нэр дэвшүүлэх, томилох, дуусгавар болгох, залгамж халааны бодлогыг тодорхойлно.
- 1.2. Энэхүү бодлогын зорилго нь группийн эрх бүхий албан тушаалтныг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх, группийн үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулах, эрх бүхий албан тушаалтны орон тоо гэнэт буюу төлөвлөгдөөгүйгээр өөрчлөгдсөнөөс үүдэн оролцогч талууд хохирохгүй байх нөхцөлийг хангахын тулд залгамж халааг тодорхойлоход оршино.
- 1.3. Энэхүү бодлогыг хэрэгжүүлэхэд Компанийн тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Санхүүгийн Зохицуулах хорооноос баталсан Компанийн засаглалын кодекс, бусад холбогдох хууль тогтоомж болон энэ бодлогыг баримтална.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 2.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо /цаашид "Хороо" гэх/ нь залгамж халааны бодлогын баримт бичгийг боловсруулж, ТУЗ-д танилцуулна.
- 2.2. Хороо нь группийн ТУЗ-ийн гишүүн, хараат бус гишүүн болон эрх бүхий албан тушаалтанд тохирох нэр дэвшигчийг тодорхойлж, санал болгоно.
- 2.3. Хороо нь эрх бүхий албан тушаалтанд дэвшүүлэх ажилтны ур чадварыг хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх, үнэлэх дүгнэх замаар нэр дэвшүүлэх, залгамж халааны бодлогыг хэрэгжүүлнэ.
- 2.4. Хороо нь группийн эрх бүхий албан тушаалтанд нэр дэвшигчид тавих шаардлагыг тодорхойлж, ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага зэргийг үнэлэх шалгуурыг тогтооно. Хороо нь группийн хүний нөөц болон гаднаас эрх бүхий албан тушаалтанд тохирох нэр дэвшигчийг тодорхойлж, санал болгоно.
- 2.5. Группийн Хүний нөөц, удирдлагын газар нь Хороонд судалгаа, тайлан хүргүүлэх, хамтарсан төлөвлөгөө гаргах замаар хамтарч ажиллана.
- 2.6. ТУЗ-өөс группийн тодорхой чиг үүргийг удирдан ажиллах чадварлаг ажилтнуудыг олж тогтоох, хөгжүүлэхэд чиглэсэн дотоод бодлого, журам, зааврыг боловсруулах эрхийг Хороонд олгож болно.
- 2.7. Нэр дэвшүүлэх хороо нь ТУЗ-ийн гишүүд болон эрх бүхий албан тушаалтан, группийн ажилтнуудын хүйсийн тэнцвэртэй байдлыг хадгалахыг зорино.
- 2.8. Группийн эрх бүхий албан тушаалтнаас тухайн жилд ажлаас чөлөөлөгдөх, шилжих хүсэлтэй байгаа эсэхт судалгаа, хийж хяналт тавина.
- 2.9. Бизнесийн шаардлага болон шинэ салбар нээх, үйл ажиллагааг өргөтгөх тохиолдолд Хорооноос эрх бүхий албан тушаалтанд ажиллах хүнийг санал болгож болно. Хороо нь группийн цаашдын өсөлттэй холбогдуулан нэр дэвшигч бэлэн байгаа эсэх, хүний нөөцийн эрсдэл тулгарч буй эсэхт үнэлэлт, дүгнэлт өгнө.
- 2.10. ТУЗ-ийн гишүүн, хараат бус гишүүн эсвэл эрх бүхий албан тушаалтан нас барсан, өөр бусад гэнэтийн шалтгаан (урт хугацааны өвчтэй, чөлөөтэй байх үеэс бусад)-ы улмаас орон тоо нь чөлөөлөгдөх тохиолдолд Хороо хуралдаж, орлох этгээдийг тодорхойлон, ТУЗ-д танилцуулж шийдвэрлэнэ.

Гурав. Залгамж халааны төлөвлөгөө

- 3.1.** Хороо нь ТУЗ-ийн гишүүн, хараат бус гишүүн, эрх бүхий албан тушаалтны орон тоо гэнэт буюу төлөвлөгдөөгүйгээр өөрчлөгдсөнөөс үүдэх эрсдэл, группийн үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулах, оролцогч талууд хохирохгүй байх нөхцөлийг хангахын тулд Залгамж халааны хөтөлбөр боловсруулж ажиллана.
- 3.2.** Өндөр насны тэтгэвэрт гарах болон таамаглаж болохуйц сул орон тоонд шаардлага хангасан нэр дэвшигчийг урьдчилан тодорхойлохын тулд Хороо болон Гүйцэтгэх удирдлага нь жил бүр давтамжтайгаар судалгаа хийнэ.

Дөрөв. Хяналт

- 4.1.** Бодлогын баримт бичгийн талаарх мэдээллийг шаардлагатай тохиолдолд Группийн цахим хуудсанд байршуулж олон нийтэд мэдээлж болох бөгөөд энэ нь Группийн Ил тод байдлын зарчимд нийцсэн үед хэрэгжинэ.
- 4.2.** Энэ бодлогын хэрэгжилтэд Хороо хяналт тавьж ажиллах ба ТУЗ-өөс энэхүү бодлогын баримт бичгийн гүйцэтгэл, үр дүнд үнэлэлт дүгнэлт өгч, хэрэгжихүйц байлгах, сайжруулах зорилгоор нэмэлт, өөрчлөлт оруулах эрхийг эдэлнэ.